## УСНЫ ГАЗРЫН 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
| **НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Усны нөөц, түүнийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах** | | | | | | | |
| Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.5.1.7, Алсын хараа -2050 урт хугацааны хөгжлийн бодлого 6.3.9, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 5.1.11, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.3.2, “Ус” үндэсний хөтөлбөрийн 3.3.19, 3.3.20, БОАЖЯ-ны стратегийн зорилт 1.3, Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3.11,3.12,3.13 | | | | | | | |
| 1.1 | **Зорилт 1.1.** Усны нөөцийн хомстолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлэх, голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх | Улсын төсөв 300.0 сая.төг<br><br>Гол мөрөн, усны нөөцийн менежмент 569.7 сая.төг | Ажлын зураг Хөв цөөрмийн тоо БОНБНҮ | Ажлын зураг -3 ТЭЗҮ-1 Тайлан-3 | Увс-2, Хэнтий, Говь-Алтай, Төв, Дорнод аймгуудын нутагт гадаргын усыг хуримтлуулах, нөхөн сэргээх ажлын зураг, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан хийгдсэн байна. Усалгааны систем 1, хөв цөөрөм 1 шинээр баригдаж, 2 сэргээн | -“Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төсөв /Хэнтий, Дадал сум/ боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.<br>-“Завхан голын голдирлыг шилжүүлж, Эрээн нуурыг сэргээх ажлын зураг төслийг боловсруулах, байгаль орчны нарийвчилсан судалгаа хийх” ажлын зураг төслийг боловсруулж Барилгын хөгжлийн төвөөр хянан магадлагаа хийлгэсэн. Байгаль орчны үнэлгээг хийлгэж ерөнхий | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | засварлагдсан байна. | шинжээчээр хянан баталгаажуулсан.<br>-“Улз голын Тээгийн боомтын байгаль орчны нарийвчилсан судалгаа хийх ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.<br>-“Увс аймгийн Хяргас сумын төвийн ногоон байгууламжийн усалгааны систем байгуулах ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Дээрх ажлуудыг олгогдсон төсдийн хүрээнд хийж дуусган, хүлээн авч санхүүжилтийг бүрэн хийсэн.<br>Төв аймгийн Баянцогт сумын нутагт хөв цөөрөм сэргээн засварлах ажил, Увс аймгийн Баруунтуруун сумын нутагт хөв цөөрөм сэргээн засварлах ажлын төсвийг 2022 оны улсын төсвийн тодотголоор хасагдсан. | |
| 1.1.1 | **Арга хэмжээ 1.1.1.** Хэнтий аймгийн Дадал сумын нутаг дахь Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв 300.0 сая.төг | Ажлын даалгавар<br>Ажил гүйцэтгэх үе шат<br><br>Ажлын зураг | Шинээр хийгдэнэ. | Ажлын даалгавар боловсруулж батлуулсан байна. Зөвлөхийг сонгон шалгаруулсан байна.<br>Ажлын зураг гаргасан байна. | Гурван нуурын усны нөөцийг нэмэгдүүлэх зураг төсөв /Хэнтий, Дадал сум/ боловсруулах ажил”-ыг гүйцэтгүүлэхээр “Престиж инженеринг” ХХК-тай БОАЖЯ/202211019 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.04.30-ны өдөр байгуулсан. Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах өдрийн өмнө буюу 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр төсөв хасагдаж, 2022 оны санхүүжилт 60.0 сая төгрөгөөр батлагдсан. | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төсөвт өртгийн үлдэгдэл 239,357,520.0 (хоёр зуун гучин есөн сая гурван зуун тавин долоон мянга таван зуун хорин) төгрөгийг 2023 оны Улсын төсөвт тусгагдсаны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулан олгохоор БОАЖЯ/202211019 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээнд тусгасан.<br>“Престиж инженеринг” ХХК БОАЖЯ/202211019 дугаартай гэрээний хавсралт №2-т тусгагдсан ажил гүйцэтгэх графикийн дагуу хээрийн судалгаа, байр зүйн зураглал, ус зүйн судалгаа, гадаргын усны дээжлэлт, байгаль орчин, нийгмийн судалгаа, геофизик, цэвдэгийн урьдчилсан судалгааг тус тус хийсэн ажлын тайланг 2022 оны 12 сарын 02-ны өдөр хүлээн авсан болно. | |
| 1.1.2 | **Арга хэмжээ 1.1.2.** Говь-Алтай аймгийн Жаргалант сумын нутаг дахь Завхан голын голдирлыг шилжүүлж, Эрээн нуурыг сэргээх ажлын зураг, байгаль орчны нарийвчилсан судалгаа хийх ажлыг зохион байгуулах | Гол мөрөн, усны нөөцийн менежмент 150.0 сая.төг | Ажлын даалгавар<br><br>Ажил гүйцэтгэх үе шат<br><br>БОНБНҮ | Төслийн судалгааны ажил хийгдсэн. | Ажлын зураг, БОНБНҮ хийх ажлын даалгавар боловсруулж батлуулсан байна. Зөвлөхийг сонгон шалгаруулсан байна. | Говь-Алтай аймгийн Жаргалант сумын нутаг дахь Завхан голын голдирлыг шилжүүлж, Эрээн нуурыг сэргээх ажлын зураг төслийг боловсруулах, байгаль орчны нарийвчилсан судалгаа хийх” ажлыг гүйцэтгүүлэхээр “Хидро-Инженеринг” ХХК-тай УГ/202202030 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан.<br>Завхан голын голдирлыг шилжүүлж, Эрээн нуурыг сэргээх ажлын зураг төслийг боловсруулан Барилгын | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| | | | | | | хөгжлийн төвөөр 2022 оны 11 дүгээр 15-ны өдрийн 2285/2022 дугаартай барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлтийг гаргуулсан. Мөн уг төслийн Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланг боловсруулан БОАЖЯ-аар батлуулахаар 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 2022/212 тоот албан бичгээр, нэмэлт материал шаардахад 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 2022/273 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн. | |
| 1.1.3 | **Арга хэмжээ 1.1.3.** Увс аймгийн Хяргас сумын төвийн ногоон байгууламжийн усалгааны систем байгуулах | Гол мөрөн, усны нөөцийн менежмент 167.48 сая.төг | Ажлын даалгавар Ажил гүйцэтгэх үе шат | Шинээр хийгдэнэ. | Ажлын даалгавар боловсруулж батлуулсан байна. Зөвлөхийг сонгон шалгаруулсан байна. | “Увс аймгийн Хяргас сумын төвийн ногоон байгууламжийн усалгааны систем байгуулах” ажлыг гүйцэтгүүлэхээр тендерт шалгарсан “ССТ-Од” ХХК-тай УГ/202201004 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.08.17-ны өдөр байгуулсан. Билүүгийн голын усан сангаас усаа татаж, ногооны талбайг услах усалгааны системийг барьж дуусган, хүлээн авах ажлын хэсгийг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/70 дугаар тушаалаар байгуулж, ажлын хэсэг уг системийг ашиглалтад хүлээн авсан. | 100 хувь |
| 1.1.4. | **Арга хэмжээ 1.1.4.** Төв аймгийн Баянцогт сумын нутагт хөв цөөрөм сэргээн засварлах | Гол мөрөн, усны нөөцийн менежмент | Ажлын даалгавар Ажил гүйцэтгэх үе шат | Ажлын зураг төсөл хийгдсэн | Ажлын даалгавар – 1. Зөвлөхийг сонгон шаларуулсан байна. | Уг ажлын төсвийг 2022 оны Улсын төсвийн тодотголоор хасагдсан. | Үнэлэх боломж гүй |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах | 101.1 сая.төг | Хөв цөөрмийн тоо | | | | |
| 1.1.5. | **Арга хэмжээ 1.1.5.** Увс аймгийн Баруунтуруун сумын нутагт хөв цөөрөм сэргээн засварлах ажлыг зохион байгуулах | Гол мөрөн, усны нөөцийн менежмент 101.1 сая.төг | Ажлын даалгавар Ажил гүйцэтгэх үе шат Хөв цөөрмийн тоо | Ажлын зураг төсөл хийгдсэн. | Ажлын даалгавар – 1. Зөвлөхийг сонгон шалгаруулсан байна. | Уг ажлын төсөв 2022 оны улсын төсвийн тодотголоор хасагдсан. | Үнэлэх боломж гүй |
| 1.1.6 | **Арга хэмжээ 1.1.6.** Дорнод аймгийн Баяндун сумын нутаг дахь Улз голын Тээгийн боомтын байгаль орчны нарийвчилсан судалгааны ажлыг зохион байгуулах | Гол мөрөн, усны нөөцийн менежмент 50 сая.төг | Ажлын даалгавар Ажил гүйцэтгэх үе шат БОНБНҮ | ТЭЗҮ, байгаль орчны төлөв байдлын судалгаа хийгдсэн. | Жилийн эцэст: Ажлын даалгавар – 1.Зөвлөхийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна. | “Улз голын Тээгийн боомтын байгаль орчны нарийвчилсан судалгаа хийх” ажлыг гүйцэтгүүлэхээр тендерт шалгарсан “Итгэлт төгөл” ХХК-тай УГ/202201007 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр байгуулсан.<br>Гүйцэтгэгч судалгааны ажлыг 10-р сард дуусгасан ба уг төслийн ажлын даалгаварт тусгаснаар Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн төслийг боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2022 оны 11 дүгээр сарын 28-ны 01/183 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 хувь |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах** | | | | | | | |
| 1.2 | **Зорилт 1.2.** Усны хэрэглээг тоолууржуулж, ус ашиглалтын үр | Төсөв шаардахгүй | Тоолуур суурилуулсан ус ашиглагч иргэн, аж | Ус ашиглалтыг тоолууржуулсан аж ахуйн нэгж 420 байна. | Ус ашиглагч аж ахуйн нэгжүүдийг тоолууржуулах, усны алдагдлыг багасгах хяналт | Нэгтгэсэн тайлан мэдээ-гаргасан.1 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиг, хэмнэлтийг сайжруулах | | ахуйн нэгжийн тоо | | тавьж, ус ашиглагч иргэн аж ахуйн нэгжийн тоолууржуулалтын тоог нэмэгдүүлсэн байна. | | 100 хувь |
| .2.1 | **Арга хэмжээ 1.2.1.** Аж ахуйн нэгж байгууллагуудад усыг зохистой ашиглах, усны нөөцийг хэмнэх, тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх, усны алдагдлыг бууруулах, ус ашиглалтыг бодитоор тооцох нөхцөлийг бүрдүүлж тоолууржуулах ажлыг эрчимжүүлэх, тайлагнах хэрэгжилтэд хяналт тавих | Төсөв шаардахгүй | Тоолуур суурилуулсан ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгжийн тоо | Тоолууржуулалтын мэдээ, тайланг нэгтгэн гаргасан. 2021 онд Тоолуур суурилуулсан аж ахуйн нэгжийн тоо 420 байв. | Жилийн эцэст: Тоолууржуулалтын мэдээ, мэдээллийг 2022 оны жилийн байдлаар нэгтгэн гаргасан байна. | Улсын хэмжээнд ус ашиглалтын тоолууржуулалтын нэгдсэн дүнг Сав газрын захиргаа, Аймаг, Нийслэлийн БОАЖГ-аас авсан мэдээллийг 2022 оны байдлаар нэгтгэн гаргахад 1108 иргэн, аж ахуйн нэгж байгууллага 2913 ширхэг усны тоолуурыг суурилуулахад нийт 204.555.810 төгрөг зарцуулсан байна. 2021 оны дүн мэдээтэй харьцуулахад өссөн дүнгээр 688 иргэн, аж ахуйн нэгж байгууллага, 2063 ширхэг тоолуурыг суурилуулахад 92.616.000 төгрөгийг.зарцуулсан | 100 хувь |
| 1.3 | **Зорилт 1.3.** Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх | Улсын төсөв 50 сая.төг | Шинэчлэн боловсруулсан стандартын төсөл | Шинэчлэн боловсруулна. | 3 стандартыг шинэчлэн боловсруулж, БОАЖЯ-нд хүргүүлсэн байна. | Стандарт шинэчлэх ажлын даалгавар- батлуулж гэрээ байгуулсан-3 | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.3.1 | **Арга хэмжээ 1.3.1.** Ус, усан орчны чанар найрлага, хаягдал ус цэвэрлэх, эргүүлэн ашиглах техникийн нөхцөл стандартыг шинэчлэн боловсруулах | Улсын төсөв 50 сая.төг | Боловсруулсан стандартын төслүүд | MNS ISO 5667-1:2002; MNS ISO 5667-11:2000; MNS 4586:1998. | Ажлын даалгавар – 1. Зөвлөхийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан. Жилийн эцэст: Зөвлөх үйлчилгээний багийг сонгон шалгаруулалтыг хийж, стандартын төслийг боловсруулж, БОАЖЯ-нд хүлээлгэж өгсөн байна. | ШУТИС-ийн Геологи гидрогеологийн салбар болон “Хидро инженеринг” ХХК-тай тус тус зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан бөгөөд багууд стандартын төслийг боловсруулан дуусгаж Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2022 оны 12 дугаар сарын 02 ны өдрийн 01/1304 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Стандарт хэмжилзүйн газрын Усны стандартчиллын үндэсний хорооны Үндэсний стандартыг дахин хянах ажлын төлөвлөгөөнд тусгуулсан. | 100 хувь |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Усны нөөцийг судалж тогтоох, усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, усны сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлэх** | | | | | | | |
| Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр ийн 5.1.2, 5.1.6,5.1.10, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 6.3.1, 6.3.3, 6.3.4, УННМТ-ий 1.1, 1.2,1.9, “Алсын хараа 2050” хөтөлбөрийн зорилгт 6.3, Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 1.1, 1.2, 1,4.1.5,1.6, 1.9, 1.10,2.14. | | | | | | | |
| 1.4 | **Зорилго 1.4.** Хөвсгөл нуурын экосистемийн бохирдлын эрсдэлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлын хэсгийг шаардлагатай мэдээ, материалаар ханган ажиллах | Төсөв шаардахгүй | Ажлын хэсгийг мэдээллээр хангасан байдал | 2020 оны ЗГ-ын 195 дугаар тогтоол Ажлын хэсгийн тушаал | Ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж, тухай бүр өгсөн үүрэг даалгаврыг 100% биелүүлсэн байна. Хөвсгөл нуурын ус зүй, усны чанар найрлагатай холбоотой мэдээ, тайланг 100% чанартай бэлдэж өгсөн байна. | Нуурын ус зүй, чанарын мэдээ тайлан -1; Ажлын хэсгийн тайлан- 1. | 100 хувь |
| 1.4.1 | **Арга хэмжээ 1.4.1.** Хөвсгөл нуурын | Төсөв шаардахгүй | Ажлын хэсэгт орж ажилласан | 2021 оны ЗГ-ын 195 дугаар тогтоол | Жилийн эцэст: Ажлын хэсгээс тухай бүр өгсөн | -Монгол улсын Ерөнхийлөгчийн ивээл доор "Хөвсгөл нуурыг хамгаалах үндэсний чуулган”-ыг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | экосистемийн бохирдлын эрсдлийн судалгаа хийж, нуурт живсэн машин техникийг татаж гаргах ажлыг зохион байгуулах Ажлын хэсэгт орж ажиллах Хөвсгөл нуурын ус зүй, усны чанар, бохирдолтой холбоотой мэдээ, тайлан гаргах | | байдал Хөвсгөл нуурын усны чанар, найрлага, ус зүйн мэдээ, тайлан | Ажлын хэсгийн тушаал, 2021 онд 1985 онд живсэн 43.3 метр урт, 8.4 метр өргөн, 5.7 метр өндөртэй “Сүхбаатар” хөлөг онгоцыг татан гаргасан. | үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан байна. Хөвсгөл нуурын ус зүй, живсэн машин техникийн байршил, усны чанар найрлагатай холбоотой цаг үеийн мэдээ, тайланг бэлтгэж, ажлын хэсэгт хамтран ажилласан байна. | 2022 оны 02 дугаар сарын 24, 25-ны өдөр зохион байгуулсан. Тус чуулганаас 4 үндсэн чиглэлээр нийт 26 арга хэмжээг хэрэгжүүлэх зөвлөмж гаргасан.<br>+БОАЖС-ын 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулсан ажлын хэсэгт Усны нөөцийн хэлтсийн дарга Я.Болдбаатар гишүүнээр ажиллаж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан. Уг ажлынхэсэг нь:<br>-Хөвсгөл нууранд живсэн автомашин бусад тээврийн хэрэгслийг татан гаргах зорилгоор тандан судалгаа хийх, байршлыг тогтоосон зураг гаргах ажлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, сав газрын захиргаа, "НБАР инженеринг" ХХК-ийн хамтарсан ажлын хэсгийг Усны нөөцийн хэлтсийн дарга Я.Болдбаатар ахлан 2022 оны 3 дугаар сарын 20-27-ны өдрүүдэд Хөвсгөл нуур дээр ажиллаж илтгэх хуудас болон ажлын тайланг БОАЖЯ, ОБЕГ-т хүргүүлсэн.<br>-“Хөвсгөл нуурын бохирдлыг бууруулах талаар авах арга хэмжээ”-ний тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 193 дугаар тогтоол, БОАЖС-ын 2021 оны А/74 дүгээр тушаал “Хөвсгөл нуурын экосистемийг хамгаалах, бохирдлыг бууруулах зорилгоор нуурт живсэн машин техникийг | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илрүүлэх татаж гаргах” ажлын хэсэгт усны газраас холбогдох дарга мэргэжилтнүүд тогтмол оролцон ажиллаж байна. ОБЕГ-БХЯ, Японы ЭСЯ болон Жайза ОУБайгуулагаас зохион байгуулсан “Хөвсгөл нуурын гүний тандан судалгаа” төсөл танилцуулах уулзалтад нийт 4 удаа оролцож усны чанар, нөөцийн талаарх мэдээллийг өгсөн. | |
| 1.5 | **Зорилт 1.5.** Усны нөөцийг тогтоож, хүн амыг баталгаат ундны усаар хангах | Улсын төсөв 1,200.0 сая.төг<br><br>Гол мөрөн, усны нөөцийн менежмент 650.0 сая.төг Хувийн хэвшил | Батлагдсан нөөц Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог нэмэгдүүлсэн байдал Тогтоосон рашааны нөөц, ордын тоо | | Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын тоог 15 мянгаар нэмэгдүүлсэн байна. Батлагдсан рашааны нөөц-1 Гидрогеологийн зураглал хийсэн газар нутгийг 15,3%-д хүргэсэн байна. | Улсын төсвийн хөрөнгөөр хийх газрын доорх усны хайгуул судалгааны ажлын батлагдсан ажлын даалгавар- 2;<br>Батлагдсан газрын доорх усны нөөц- 1; (20 л/с буюу 1728 $м^3$/хон)<br>Рашааны нөөц тогтоосон ордын тоо-1<br>Батлагдсан нөөц 25.2 $м^3$/7цаг-хон). | 100 хувь |
| 1.5.1 | **Арга хэмжээ 1.5.1.** Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг зохион байгуулах | Улсын төсөв 1,200.0 сая.төг | Хайгуул судалгааны ажил Батлагдсан нөөц Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын тоог | 2021 онд хайгуул судалгааны ажил-2<br>Нөөцийг 114.8 л/сек-ээр батлуулсан. Хүн амын унд ахуйн усны хэрэглээг баталгаат түвшинд хүргэсэн хүн амын тоог | Жилийн эцэст:<br>Хайгуул судалгааны ажлыг 4 сум, сууринд хийх ажлын даалгавруудыг боловсруулан, БОАЖЯ-ны ТНБД-аар батлуулсан байна. Зөвлөхийг сонгон шалгаруулж, | 2022 онд улсын төсвийн хөрөнгөөр дараах 4 сумын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн. Үүнд:<br>-Говь-Алтай аймгийн Төгрөг сум-Дундговь аймгийн Эрдэнэдалай сум--Дорноговь аймгийн Дэлгэрэх сум--Өмнөговь аймгийн Сэврэй сум | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэмэгдүүлсэн байдал | 30,700-аар нэмэгдүүлсэн. | ажил гүйцэтгэх гэрээг хийсэн байна | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу дээрх 4 багц ажлын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 2022 оны 1 дүгээр улиралд зохион байгуулж шалгаруулсан боловч Улсын төсвийн тодотголоор батлагдсан 1.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хасагдаж, 240 сая төгрөгийн санхүүжилт үлдсэн тул Дорноговь аймгийн Дэлгэрэх суманд хайгуул хийхээр шийдвэрлэсэн. Гүйцэтгэгчээр усны хайгуул судалгаа хийх эрхтэй "Таширын хүрээ" ХХК шалгарсан бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр Дугаар № БОАЖЯ/202211021/01/01 дугаартай гэрээ байгуулж батлагдсан даалгаврын дагуу хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Усны газрын даргын 2022 оны А/46 тушаалаар байгуулсан ажлын хэсэг "Таширын хүрээ" ХХК-ийн хээрийн судалгааны ажлын явцад хяналт тавих ажлыг 2022 оны 08-р сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулсан. Хээрийн судалгааны ажлын хүрээнд эрлийн 3, хайгуулын 2, хяналт-шинжилгээний 1 цооног өрөмдсөн бөгөөд газрын доорх усны ордыг урьдчилсан байдлаар үйлдвэрлэлийн С зэргээр 5л/сек нөөц тогтоосон. | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Усны нөөцийн зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн III хуралдаанаар Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын төвийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны нөөцийг хэлэлцүүлж, гишүүдийн 100 хувийн саналаар нөөцийг Улсын усны нэгдсэн мэдээллийн санд хүлээж авсан. | |
| 1.5.2 | **Арга хэмжээ 1.5.2.** Рашааны нөөцийг тогтоох хайгуул судалгааны ажлыг нэмэгдүүлэх | Хувийн хэвшлийн хөрөнгөөр | Рашааны нөөц тогтоосон ордын тоо | 2021 онд Батлагдсан рашааны нөөц | Эхний хагас жилд: Рашааны хайгуул судалгааны 1 тайланг Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулсан байна.<br>Жилийн эцэст: Рашааны хайгуул судалгааны 1 тайланг Усны зөвлөлөөр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах;<br>Жилийн эцэст: Батлагдсан рашааны нөөц-1 | “Оргил рашаан сувилал” ХХК-ийн захиалгаар “Ньюгидро проект” ХХК-ийн гүйцэтгэсэн Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 18-р хорооны нутаг дэвсгэрт “Оргил рашаан сувилал” ХХК-ийн нүүрсхүчлийн хийт хүйтэн рашааны ашиглалтын хайгуулын гидрогеологийн судалгааны ажлын үр дүнг Усны нөөцийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Оргил нүүрсхүчлийн хийт хүйтэн рашааны нөөцийг B+C зэргээр 25.2м$^3$/7цаг-хоног нөөцийг баталсан. | 100 хувь |
| 1.5.3 | **Арга хэмжээ 1.5.3.** Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтоох | Гол мөрөн, усны нөөцийн менежмент 650.0 сая.төг | Гидрогеологийн дунд масштабын зураглал хийсэн газар нутгийн эзлэх хувь | 2019 онд гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг нийт нутаг дэвсгэрийн 14.8%-д хүргэсэн. | Жилийн эцэст: Гидрогеологийн дунд масштабын зураглал хийх ажлын даалгаврыг батлуулах, сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан байна. Тайлан-1 | Гидрогеологийн дунд масштаб (1:200000)-ын зураглал хийсэн газар нутгийн хэмжээг (14.8%) нэмэгдүүлж, 15.3 хувьд хүргэх зорилтын хүрээнд 2022 онд Дорноговь аймгийн Дэлгэрэх, Өргөн сум, Сүхбаатар аймгийн Баяндэлгэр Уулбаян, Халзан, Түвшинширээ, Асгат, Онгон, Баруун-Урт сумдын нутагт (Хавтгай: L-49-XVII, XVIII, XXII, | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | XXIII, XXVIII (хагас), XXIX (хагас) ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 550.0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэх ажилд “Дунар-Од” ХХК шалгарч 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Дугаар № УГ/202202029 гэрээ байгуулсан. Ажлын үр дүн, тайланг Усны нөөцийн зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Гидрогеологийн 1:200 000 хураангуйлалтай зураглалын ажлын үр дүнг хэлэлцүүлж, тайланг гишүүдийн 100 хувийн саналаар хүлээж авсан. | |
| 1.6 | **Зорилт 1.6.** Монгол Улсын төрөөс усны талаар баримталж буй бодлогын баримт бичиг, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, салбар дундын зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах | Төсөл хөтөлбөр | Улсын УННМТ-ний хэрэгжилтийн хувь<br>Сав газрын УННМТ-ний төсөл<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Улсын УННМТ-ний нийт хугацааны хэрэгжилт 61 хувь<br>4 сав газрын УННМТ-ний төсөл 35-80 хувьтай<br>Зохион байгуулсан арга хэмжээний тоо - 5 | Улсын УННМ-ийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна.<br>6-аас доошгүй сав газрын УННМТ-ний төслийг батлуулахаар БОАЖЯ-нд хүргүүлсэн байна.<br>Улсын болон сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, сав газрын захиргаадыг бэхжүүлэх чиглэлээр 6-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | Шинэчлэн боловсруулсан сав газрын УННМ-ийн төлөвлөгөө – 3;<br><br>Зохион байгуулсан арга хэмжээ - 3. | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6.1 | **Арга хэмжээ 1.6.1.** Улсын УННМТ-г боловсруулах | Төсөл хөтөлбөр | УННМТ-ний төсөл | Улсын УННМТөлөвлөгөөний нийт хугацааны хэрэгжилт-61 хувь Хэрэгжилтийн үнэлгээний тайлан-1 | Жилийн эцэст: Улсын УННМТ-г байгаль орчны зорилтот хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, Улсын УННМИөлөвлөгөөний төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн байна. | Улсын УННМТ-ний төслийг 4 стратеги зорилгын хүрээнд 19 зорилт, 78 арга хэмжээ 2030 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөн боловсруулж, төслийг Усны газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдөр 01/505 дугаартай албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн. Төлөвлөгөө боловсруулахад талуудын оролцоог хангах хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан. Анхны цуврал хэлэлцүүлгийг үйл ажиллагаанд тусгах ажил, саналуудыг цуглуулах зорилгоор 12 удаагийн уулзалтуудыг хийж 500 гаруй санал авч холбогдох санал, зөвлөмжийг тусгасан болно.<br>Монгол Улсын Их Хурлаас 2020 онд шинэчлэн баталсан Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.3 дахь заалтыг үндэслэн Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг 5 жилээр хэрэгжүүлэхээр төлөвлөж, нэмэлт өөрчлөлт оруулах тухай БОАЖЯ-ны УБЗГ-аас өгсөн санал зөвлөмжийг дагуу төлөвлөгөөний төсөлд холбогдох засвар, өөрчлөлтүүдийг хийж 2022 оны 11 дүгээр сарын 14, 23-ны өдрүүдэд цахимаар Байгаль | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | орчин, аялал жуулчлалын яамны Усны бодлого, зохицуулалтын газарт хүргүүлсэн. | |
| | | | | | | | |
| 1.6.2 | **Арга хэмжээ 1.6.2.** Сав газрын УННМТ-г батлагдсан аргачлалын дагуу боловсруулах ажлыг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах | Төсөл хөтөлбөр | Шинэчлэн боловсруулсан сав газрын УННМТ-ний төсөл | 4 сав газрын УННМТ шинэчлэн боловсруулах ажлын явц 35-80 хувьтай. | Жилийн эцэст: 3-аас доошгүй сав газрын УННМТ-ний шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, төслийг БОАЖЯ-нд хүргүүлсэн байна. | Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэйгээр "Цэнгэг усны хүрээлэн" ТББ, сав газрын захиргаа хамтран боловсруулсан.<br>-Увс нуур-Тэсийн голын сав газрын УННМТ-ний төслийг салбарын эрдэмтэн судлаачдад танилцуулж санал, зөвлөмж авах хэлэлцүүлгийг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр,<br>-Хар нуур-Ховд гол, Хяргас нуур-Завхан голын сав газрын төлөвлөгөөг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр тус тус зохион байгуулсан.<br>Төлөвлөгөөний төсөлд хэлэлцүүлэгт оролцогчдоос өгсөн санал, зөвлөмжийг тусгаж, Хар нуур, Ховд голын сав газрын захиргаанаас 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 281 дугаар албан бичгээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Усны бодлого, кохицуулалтын газарт хүргүүлсэн... | 100 хувь |
| 1.6.3 | **Арга хэмжээ 1.6.3.** Сав газрын УННМТ-г хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтэд | Төсөл хөтөлбөр | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | Зохион байгуулсан арга хэмжээний тоо 5 | Сав газрын УННМТ-ний хэрэгжилтийг эрчимжүүлэх, захиргаадын үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр 3-аас | -“Усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь” сургалт хэлэлцүүлгийг 21 сав газрын захиргаадын 180 гаруй албан хаагчид 2022 оны 5 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалт | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хяналт тавих, сав газрын захиргаадыг бэхжүүлэх, мэргэжилтнүүдийг чадавхжуулах үйл ажиллагаа зохион байгуулах | | | | доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | танхим, дадлага хосолсон хэлбэрээр явагдаж, оролцогчдыг шаардлагатай мэдээ мэдээллээр ханган ажилласан.<br>-Усны газрын даргын 2022 оны 01/35 тоот албан бичгээр Удирдлагын академид 21 сав газрын захиргаадын төрийн захиргааны жинхэнэ албан хаагчдыг мэргэшүүлж бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх сургалтын захиалгыг хүргүүлж 10 сав газрын захиргаадын албан хаагчийг хамруулсан. Үүнд: ахлах түшмэл-1, төрийн албанд шинээр томилогдсон-5, давтан сургалтанд - 5 тус тус суралцаж төгссөн. 4 сав газрын захиргааны дарга нарыг ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдах захилгат сургалтын гэрээг Удирдлагын академитай байгуулсан.<br>-Дэлхийн байгаль хамгаалах сангийн дэмжлэгтэйгээр Баруун бүсийн сав газрын захиргаадын мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтыг 2022 оны 09-р сард Баян-Өлгийн аймагт Хар нуур-Ховд голын сав газрын захиргаатай хамтран зохион байгуулсан. Тус сургалтад нийт 9 сав газрын 100 гаруй албан хаагч оролцсон. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | **Зорилт 1.7.** Усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хамгаалалтад авах | Улсын төсвийн хөрөнгө 500.0 сая.төг<br><br>Орон нутаг Бусад | Ажил гүйцэтгэх үе шат, Үндэслэл судалгаа<br><br>Арга хэмжээ<br><br>Нэмэгдүүлсэн цэгийн тоо<br><br>Загварчлалын тайлан | Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 49.9 хувийг улсын тусгай хамгаалалтад авсан. Улсын хэмжээнд нийт 16 аймагт Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, ИТХ-аар батлуулсан. 2021 онд усны хяналт шинжилгээний цэг 309 болсон. Газрын доорх усны ордод хийсэн загвар – 4 | Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэл-2.<br>3-аас доошгүй ААНБ-д усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлж, хяналт тавьж ажилласан байна.<br>1 аймгийн усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүс батлагдсан байна.<br>Хяналт-шинжилгээний цэгийн тоог 319 болгосон байна.<br>Газрын доорх усны ордод загвар-2 хийсэн байна. | Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан талбай -226,175.9 га;<br>Хяналт шалгалтын тоо -2;<br>Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах тухай ААНБ-д өгсөн зөвлөмжийн тоо – 30;<br>Усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрүүдийн хамгаалалтын бүс тогтоолгох үндэслэл боловсруулсан аймгийн тоо – 1;<br>Зүүн бүрд нуурыг сэргээх ажлыг гүйцэтгэл-100 хувь<br>Аварга тосон нуурыг сэргээх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлын гүйцэтгэл - 50 хувь<br>Шинээр байгуулж, тоноглох газрын доорх усны хяналт-шинжилгээний цооногийн тоо - 10. | 100 хувь |
| 1.7.1 | **Арга хэмжээ 1.7.1.** Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах үндэслэл боловсруулахад СГЗ-дад дэмжлэг үзүүлэх | Орон нутаг Бусад | Ажил гүйцэтгэх үе шат Үндэслэл судалгаа | Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 49.9 хувийг улсын тусгай хамгаалалтад авсан байна. | Жилийн эцэст: Хөвсгөл, Хэнтий аймгийн нутагт харьяалагдах цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэхийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авах үндэслэл | Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтанд авах үндэслэл боловсруулах, усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсврийн хамгаалалтын бүс тогтоох чиглэлээр СГЗ-дад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан бөгөөд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын иргэдийн төлөөлөгчдийн | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулахад мэргэжил аргазүйгээр хангаж ажилласан байна. Үндэслэл-2 | хурлын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 02 дугаар тогтоолоор “Ямаат-Шаварын голын эх” орчмын газар нутаг болох 226,175.9 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад 2042 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 20 жилийн хугацаагаар авсан | |
| 1.7.2 | **Арга хэмжээ 1.7.3.** Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, нэгдсэн сүлжээнд холбох ажил, газрын доорх усны орд газарт загварчлал гаргах | Улсын төсөв 500.0 сая.төг | Нэмэгдүүлсэн цэгийн тоо | Газрын доорх усны хяналт шинжилгээний 309 цэгийн мэдээлэл www.groundwater.mn нэгдсэн сүлжээнд холбогдсон. Үүнд: 58 бүрэн автомат, 249 хагас автомат, 2 гар хэмжилтийн цэгтэй ажиллаж байна. | Жилийн эцэст: Газрын доорх усны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлж, нэгдсэн сүлжээнд холбох ажлын даалгавар боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж, өрөмдлөгийн ажлыг эхлүүлсэн байна. | Газрын доорх усны хяналт-шинжилгээний сүлжээг 10 цооногоор өргөжүүлж, нэгдсэн сүлжээнд холбох ажлын гүйцэтгүүлэхээр тендерт шалгарсан. “Карст”ХХК, “КПМ” ХХК-тай 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр УГ/202201002/ дугаартай гэрээ байгуулж, Өмнөговь аймгийн Ноён суманд 2, Баяндалай суманд 1, Дорноговь аймгийн Сайхандулаан суманд 2, Мандах суманд 2, Өргөн суманд 2 цооног, Айраг суманд 1 цооног нийт 10 мониторингийн цооногоор сүлжээг өргөтгөж, нэгдсэн сүлжээнд холбосон. 2022 оны 12 дугаар сарын байдлаар улсын хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээнд 319 мониторингийн цооногт суурилуулсан автомат болон хагас автомат багажаар дараах 4 үзүүлэлтээр хийж байна.<br>-Газрын доорх усны түвшин<br>-Температур<br>-Цахилгаан дамжуулах чанар<br>-Агаарын даралтыг 6 цаг тутам хянаж, бүртгэж байна. | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өмнөгөвь аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар 3, “Өсөх Зоос” ХХК-ийн санхүүжилтээр 1 газрын доорх усны хяналт шинжилгээний цооногийн хагас автомат багаж тоног төхөөрөмжийг бүрэн автомат болгож нэгдсэн сүлжээнд холбосон. | |
| 1.7.3 | **Арга хэмжээ 1.7.4.** Газрын доорх цэнгэг усны орд, уул уурхайд ашиглаж байгаа газрын доорх усны ордуудад загварчлал хийх | Төсөв шаардахгүй | Газрын доорх усны загварчлалын тайлан | 2021 онд Газрын доорх усны ордод гаргасан загвар – 2 | Жилийн эцэст: Говийн бүсийн цэнгэг усны Зайрмагтайн ордод-1 газрын доорх усны загварчлал гаргасан байна. тайлан -1. | Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дэвсгэрт орших Зайрмагтайн газрын доорх цэнгэг усны ордын загварчлалыг ArcGIS, ENVI, ModFlow программ хангамжид тулгуурлан хийсэн. | 100 хувь |
| 1.8 | **Зорилт 1.8.** Усны тоо бүртгэл, статистик мэдээлэл, кадастр, улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх | Төсөв шаардахгүй | Улсын усны мэдээллийн санд оруулсан сав газрын мэдээ бүрдүүлэлтийн хувь | Улсын усны мэдээллийн санд 21 Сав газрын захиргаадын 2021 оны усны тоо бүртгэл, мэдээг оруулсан. | Мэдээллийн санд оруулсан өмнөх оны дүн мэдээнд засвар хийнэ. Шинээр нэвтрүүлсэн дүн шинжилгээ хийх программ, дүгнэлт оруулах программыг 100 хувь хөгжүүлж, мэдээллийг оруулсан байна. | 2022 оны усны тоо бүртгэл, мэдээ мэдээллийн бүрдэл<br><br>2021 оны БОХ 2.1, БОХ 2.2 маягтыг хуулийн хугацаанд хянасан гүйцэтгэлийн биелэлт – 100 хувь. | 100 хувь |
| 1.8.1 | **Арга хэмжээ 1.8.1.** Улсын усны мэдээллийн сан eic.mn-д сав газрын захиргаадын мэдээллийг төвлөрүүлэх, БОАЖГ-ын | Төсөв шаар-дахгүй | Программын /2/ хөгжүүлэлт мэдээ бүрдүүлэлтийн хувь Өмнөх оны мэдээллийн зөрүүгийн | Улсын усны мэдээллийн сан 29 сав газрын 2021 оны усны тоо бүртгэл, мэдээ мэдээллүүдийг оруулсан. | Жилийн эцэст: Улсын усны мэдээллийн санд өмнөх оны мэдээллүүдийг хянаж, зөрүүг засаж оруулсан байна. 2021 оны БОХ 2.1, БОХ 2.2 маягтыг | Байгаль орчны мэдээллийн сангийн (eic.mn) ус, рашааны мэдээллийн дэд санд 21 сав газрын захиргааны 2022 оны усны тоо бүртгэлийн мэдээллийг байршуулсан. 2022 онд Улсын хэмжээнд 188 булаг шандыг хашиж хамгаалсан. | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаль орчны мэдээллийн санд оруулсан БОХ 2.1, БОХ 2.2 маягтад хяналт тавих | | засвар хийсэн байдал БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дүн мэдээ | 2020 оны БОХ 2.1, БОХ 2.2 маягтыг хуулийн хугацаанд хянасан. | хуулийн хугацаанд хянаж, байгаль орчны мэдээллийн санд оруулсан байна. | Байгаль орчны статистик мэдээг БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж, тоон мэдээллийн бүрдүүлэлт хийж дууссан. 2021 онд Улсын хэмжээнд гол, горхи 6767; нуур, тойром 4352; булаг, шанд 13576; хөв цөөрөм 238 усны тоо бүртгэлээр тоологдсон. Үүнээс сэргэсэн гадаргын урсац 670; хатаж ширгэсэн гадаргын урсац 458 бүртгэдсэн | |
| **ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Усны нөөц, түүнийг зохистой ашиглах усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах** | | | | | | | |
| Усны тухай хуулийн 28.4, 28.7, $16^1$.4.9, $16^1$.4.10, Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 3.11,3.12,3.13. | | | | | | | |
| 1.9 | **Зорилт 1.9.** Ус ашиглалтыг зохицуулах, хяналт тавих, ус ашиглалтын мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргах | Төсөв шаардахгүй | Дүгнэлтийн тоо<br>Хянасан гэрээ, зөвшөөрлийн тоо<br>Ус ашиглалтын мэдээ, тайлан | Улсын хэмжээнд дунджаар жилд 560-590 сая $м^3$ ус ашиглаж байна. Ус ашиглалтын мэдээ тайлан 100% нэгтгэгдсэн. | Монгол орны тухайн жилийн ус ашиглалтын мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэн гаргасан байна. | 2021 оны ус ашиглалтын хэмжээ (594.8 сая.$м^3$/жил)-г салбараар улсын хэмжээнд нэгтгэж, мэдээ тайланг гаргасан.<br>2022. оны 12 дугаар сарын 01-ний байдлаар ус ашиглуулах дүгнэлтийг томоохон ус ашиглагч, сав газрын захиргаа, аймаг, нийслэлээр мэдээллийг улсын хэмжээнд нэгтгэхэд урьдчилсан байдлаар тооцсон нийт усны хэмжээ 369,802.0 мян.$м^3$/жил, төлбөр ногдуулсан төлбөрийн хэмжээ 69,768.7 сая.төгрөг байна. | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022 онд сав газрын захиргаа болон аймаг, нийслэлийн гаргасан ус ашиглуулах 368 дүгнэлт, 141 зөвшөөрөл, 108 гэрээ, зөвшөөрөлд хяналт тавин ажилласан. | |
| 1.9.1 | **Арга хэмжээ 1.9.1.** Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллагад ус ашиглуулах дүгнэлт гаргах | Төсөв шаардахгүй | Дүгнэлтийн тоо | 2021 онд 29 усаар хангагч байгууллагад дүгнэлт гаргасан. Жил бүр хийгдэнэ. | Жилийн эцэст: Усаар хангагч байгууллагуудад дүгнэлт гаргаж, ус ашиглалтын мэдээллийг тайлагнасан байна. | 2022 онд усаар хангагч 28 байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, ус ашиглалтын мэдээллийг тайлагнасан.<br>Урьдчилсан байдлаар төлбөр ногдуулсан усны хэмжээ 15,810.39 мян.м$^3$/жил, нийт төлбөрийн дүн 149.3 сая.төгрөг байна. | 100 хувь |
| 1.9.2 | **Арга хэмжээ 1.9.2.** Хоногт 100 шоо метрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлт гаргах | Төсөв шаардахгүй | Дүгнэлтийн тоо | 2021 онд 182 аж ахуйн нэгжид ус ашиглуулах дүгнэлт гаргасан. Жил бүр хийгдэнэ. | Жилийн эцэст: Ус ашиглуулах дүгнэлтийг хууль дүрэм журамд нийцүүлэн хуулийн хугацаанд нь гаргаж, ус ашиглалтын мэдээллийг хагас жилийн байдлаар нэгтгэн гаргасан байна. | 2022 оны 208 аж ахуй нэгж, байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, мэдээллийг салбараар, сав газрын захиргаа, аймаг, нийслэлээр нэгтгэн гаргасан. Урьдчилсан байдлаар төлбөр ногдуулсан усны хэмжээ 168,557.5 мян.м$^3$/жил, нийт төлбөрийн дүн 69,619.4 сая.төгрөг байна. | 100 хувь |
| 1.9.3 | **Арга хэмжээ 1.9.3.** Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавих | Төсөв шаардахгүй | Зөвлөмжийн тоо | 2021 онд 38 зөвшөөрөл, 34 гэрээг хянаж, 10 СГЗ-нд санал зөвлөмж хүргүүлсэн. | Жилийн эцэст:: Санал, дүгнэлт, зөвлөмж 5-аас доошгүйг хүргүүлсэн байна. | 2022 онд сав газрын захиргаа (СГЗ)-дын гаргасан ус ашиглуулах 203 дүгнэлт, 121 зөвшөөрөл, 108 гэрээ болон аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлал (БОАЖГ)-ын газраас гаргасан ус ашиглуулах 165 дүгнэлт, 20 зөвшөөрөл, гэрээнд хяналт | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тавин ажиллаж, санал, дүгнэлт, зөвлөмжийг өгсөн.<br>Усны газрын даргын 2022 оны 5 дугаар сарын12-ны өдрийн А/28 дугаар тушаалаар баталсан "Ус ашиглуулах дүгнэлт гаргах заавар, загвар"-ыг СГЗ-д болон аймаг, нийслэлийн БОАЖГ-уудад хүргүүлсэн.<br>СГЗ болон аймаг, нийслэлийн БОАЖГ-уудаас 2021 онд гаргасан ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг нэгтгэн гаргаж, Үндэсний статистикийн газарт хүргүүлсэн.<br>2022 оны 5 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд зохион байгуулсан "Усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь" сэдэвт СГЗ, аймаг, нийслэлийн БОАЖГ-ын удирдлага, мэргэжилтнүүдийг хамруулсан сургалт, хэлэлцүүлэгт илтгэл тавьж, санал солилцон, зөвлөгөө өгч оролцсон.<br>СГЗ болон аймаг, нийслэлийн БОАЖГ-ын усны асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд ус ашиглуулах дүгнэлт гаргах, зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах, тэдгээрт хяналт тавих талаар зөвлөгөөг утсаар өгч, И-мэйл-ээр хүргүүлж ажилласан.<br>СГЗ-дын удирдлага, мэргэжилтнүүдэд Усны газраас 2022 оны 11 дүгээр сарын 10-ны | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдөр цахимаар зохион байгуулсан сургалтад “Ус ашиглуулах дүгнэлт гаргахад анхаарах асуудал” сэдвээр танилцуулга хийж, ус ашиглуулах дүгнэлийн маягтыг хэрхэн бөглөх талаар заавар өгсөн.<br>2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр Нийслэлийн БОГ, аймгуудын БОАЖГ-ын ус хариуцсан мэргэжилтнүүдтэй онлайн уулзалт зохион байгуулж, БОХ маягт бөглөх болон ус ашиглуулах дүгнэлтийг гаргах талаар зөвлөмж өгч, ажилласан. | |
| 1.10 | **Зорилт 1.10.** Голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах | Төсөв шаардахгүй | Ирүүлсэн хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байдал | Усны барилга байгууламжийн зураг төсөлд 18 дүгнэлт гаргасан. | Усны барилга байгууламжийн зураг төсөл хийлгэхээр ирүүлсэн хүсэлтийг хуулийн дагуу шийдвэрлэж дүгнэлт гаргасан байна. Төслүүдийн талаарх нэгдсэн танилцуулга-1 | Усны барилга байгууламжийн зураг төсөлд дүгнэлт гаргуулахаар хүсэлтээ ирүүлсэн 10 аж ахуйн нэгжийн хаягдлын сангийн зураг зураг төсөлд дүгнэлт, зөвлөмжийг хугацаанд нь гарган хүргүүлсэн. | 100 хувь |
| 1.10.1 | **Арга хэмжээ 1.10.1.** Голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, | Төсөв шаардахгүй | Ирүүлсэн хүсэлтийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байдал | Усны барилга байгууламжийн зураг төсөлд 18 дүгнэлт гаргасан.<br><br>Жилд орж ирэх зураг төслийн тоо тодорхойгүй байна. | Жилийн эцэст. Ирүүлсэн бүх төсөлд дүгнэлтийг хууль дүрэм журамд нийцүүлэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх 1 дүгнэлт, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын хаягдлын сангийн 1 зураг төсөлд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 3 аж | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах | | Нэгдсэн танилцуулга мэдээлэл -1 | | | ахуйн нэгжийн 3 дүгнэлтийн материалыг судалж, зөвлөмж, дүгнэлт хүргүүлсэн. | 100 хувь |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, цэвэрлэсэн болон саарал усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах** | | | | | | | |
| Усны тухай хуулийн 7.4, 16'1.3, 16'4.5, 16'4.6, 16'4.8, 24.2, 24.5, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 5, 6 дугаар зүйл. Усны газрын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 4.15,4.16,4.17,4.18, Засгийн газрын 2019 оны “Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээ” тогтоосон 316 дугаар тогтоол. | | | | | | | |
| 1.11 | **Зорилт 1.11.** Усны нөөцийг бохирдлоос хамгаалах, бохирдуулагч нь төлөх зарчмыг хэрэгжүүлэх | Төсөв шаардахгүй | Дүгнэлтийн тоо<br>Хянасан гэрээ, зөвшөөрлийн тоо<br>Төлбөр, нөхөн төлбөрийн мэдээ | 2021 онд хоногт 50 $м^3$-ээс бага хаягдал ус гаргадаг 952, хоногт 50 $м^3$-ээс их хаягдал ус гаргадаг 101 ус бохирдуулагчид хаягдал усны дүгнэлт гаргасан. Усны газраас ногдуулсан хаягдал усны төлбөр-12,3 сая.төг, СГЗ-наас ногдуулсан төлбөр-86,6 сая.төг байна. Хаягдал усны төлбөр, усны чанарын улсын дүн мэдээ, тайлан гарсан. | Монгол орны тухайн жилийн хаягдал усны төлбөр, усны чанарын дүн мэдээ, тайлан гарсан байна.<br>Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөөний 2022 оны биелэлтийн тайлан<br>УБ хот дахь 12 чиглэлийн үйлдвэрүүдийн хаягдал усны нормыг тогтоосон суурь судалгаа-1<br>Судалгаанд үндэслэн 12 чиглэлийн үйлдвэр, ААНБ-дад зөвлөмж хүргүүлсэн байна. | Дүгнэлтийн тоо-60<br>Хянасан гэрээ, зөвшөөрлийн тоо-125<br>Төлбөр, нөхөн төлбөрийн мэдээ, мөнгөн дүн | 100 хувь |
| 1.11.1 | **Арга хэмжээ 1.11.1.** Хоногт 50 шоо метрээс их эсхүл аюултай бохирдуулах бодис бүхий | Төсөв шаардахгүй | Дүгнэлт гаргасан байдал | Усны газар 2021 онд 88 ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын | Эхний хагас жилд: Хаягдал усны дүгнэлтийг гаргаж, хуулийн хэрэгжилтийг сайжруулж, хаягдал | Усны газраас Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 2022 оны хаягдал усны 120 аж ахуйн нэгж | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид хаягдал усны дүгнэлт гаргах, улсын дүн мэдээг нэгтгэн гаргах | | Нэгтгэсэн мэдээ, тайлангийн чанар | хаягдал усны дүгнэлтийг гаргасан.<br><br>Жил бүр хийгдэнэ. | усны 50 ААНБ-ын дүгнэлтийг хуулийн хугацаанд нь гаргаж, хаягдал усны чанарын төлөв байдлын мэдээ, мэдээллийг нэгтгэж, тайлагнасан байна.<br>Жилийн эцэст: 100-аас доошгүй ААНБ-ын дүгнэлтийг хуулийн хугацаанд нь гаргаж, төлбөр, нөхөн төлбөрийн тооцоо судалгааг сав газар, салбараар нэгтгэн гаргасан байна. | байгууллагын хаягдал усны дүгнэлтийг гаргаж, 2.8 тэрбум төгрөгийг ногдуулснаас 2.3 тэрбум төгрөгийг хөнгөлж, чөлөөлсөн байна.<br>2022 онд Ус бохирдуулсны төлбөрөөс нийт 1.63 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. | 100 хувь |
| 1.11.2 | **Арга хэмжээ 1.11.2.**<br>СГЗ-дын ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулсан талаарх мэдээллийг нэгтгэж, мэргэжил арга зүйгээр хананган ажиллах | Төсөв шаардахгүй | Төлбөрийн гэрээнд хяналт тавьсан байдал, Төлбөрийн гэрээний тоо<br><br>Нэгтгэсэн мэдээ, тайлангийн чанар | Сав газрын захиргаад 2021 онд 74 төлбөрийн гэрээг байгуулсан байна.<br><br>Жил бүр хийгдэнэ. | Жилийн эцэст: Хаягдал усаа байгальд шууд нийлүүлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай СГЗ-ны байгуулсан 2021 оны ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, гэрээ дүгнэсэн байдалд хяналт тавьж, зөвлөмж хүргүүлж ажилласан байна. | Усны газрын гаргасан дүгнэлтийг үндэслэн хаягдал усаа байгальд шууд нийлүүлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай Сав газрын захиргаад 120 төлбөрийн гэрээг байгуулж ажилласан байна. 2022 онд Сав газрын захиргаанаас гаргасан дүгнэлтийг хянан нэгтгэхэд 3518 дүгнэлтээр нийт 161.8 сая.төг ногдуулснаас эрүүл мэндийн 155 байгууллагын 63.5 сая.төг, боловсролын 374 байгууллагын 34.3 сая.төгрөгийг 100 хувь хөнгөлж, 2986 ААНБ-д 64.0 сая.төг ногдуулсанаас айл өрхийн чөлөөлөгдсөн төлбөрийг хасч тооцоход 58.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.11.3 | **Арга хэмжээ 1.11.3.** Засгийн газрын 2020 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-нд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, биелэлтийг холбогдох газарт хүргүүлэх | Засгийн газрын 2020 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан төсөв | Ажлын хэсэгт шаардлагатай мэдээ, материалыг гаргаж, тайланг цаг тухайд нь хүргүүлсэн байна. /нийт 3 удаа/ | 2021 онд ҮХУУЦТ-ний хэрэгжилтийг хангаж, Усны газраас хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг холбогдох газарт /3 удаа/ хүргүүлсэн. | Эхний хагас жилд: УБ хот дахь 12 чиглэлийн үйлдвэрүүдийн хаягдал усны бохирдлын ачааллыг улирал болон процессоос хамааруулан хязгаар тогтоох судалгаа хийж, үйлдвэрүүдийн урьдчилан цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал усны норм хэмжээг тогтоох Зөвлөх үйлчилгээний багийн сонгон шалгаруулалтанд оролцоно. Ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байна.<br>Жилийн эцэст:<br>-Боловсруулсан гарын авлагыг хүлээн авч, ААНБ-д урьдчилан цэвэрлэх байгууламжийг технологийг дагуу суурьлуулах ажлыг зөвлөмж болгон ажилласан байна.<br>-ҮХУУЦТ-ний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын | 1.Барилга, хот байгуулалтын Сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны 161 дүгээр тушаалаар байгуулагдсан ҮХУУЦТ-ний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн хурлуудад оролцосон. Усны газраас хийж хэрэгжүүлж буй ажлын тайланг улирал бүр /4 удаа/ ажлын хэсгийн нарийн бичгийн дарга БХБЯ-ны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч П.Ганбаатарт 2022.03.10, 2022.05.10, 2022.08.10, 2022.11.20-ны өдөр /ganbaatar0224@mcud.gov.mn/ цахим хаягаар хүргүүлж ажилласан.<br>2.Бохирдуулагч үйлдвэрүүдийн бохир усыг стандартад нийцүүлэх, үйлдвэрлэлийн чиглэл бүрээр урьдчилан цэвэрлэх байгууламжийн технологийн заавар бүхий гарын авлага, баримт бичиг гаргах, хаягдал усны хэмжээ, бохирдлын түвшний мэдээллийн санг баяжуулж, ТЦБ, байгаль орчинд нийлүүлж буй хаягдлыг хянах, ерөнхий өгөгдлийн шинжилгээг хийх боломжтой мэдээллийн санг хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулах ажлын хэсэгт орж ажилласан. Тус ажлын хүрээнд | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэсгийн хурлуудад оролцож, шаардлагатай материалыг гаргаж, Усны газраас хийж хэрэгжүүлж буй ажлын тайланг улирал бүр /4 удаа/ хүргүүлж ажилласан байна. | хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Astivision” ХХК-тай хамтран ажиллаж байна.<br>3.Ус бохирдуулсны төлбөрийг бохирдуулагч бодис тус бүрээр тооцох маягтын загвар, Ус бохирдуулсны төлбөрийн тайлангийн маягтыг Татварын Ерөнхий Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/50 тоот тушаалаар батлуулан Татварын ерөнхий газрын татварын цахим системд оруулсан.<br>4.МХЕГ-ын тэргүүн дэд даргын баталсан 01/01 дугаартай “Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн цэвэрлэсэн бохир усанд хяналт шинжилгээ хийх” удирдамжийн дагуу МХЕГ, НМХГ, МСС, Усны газар, ОББҮХ, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл, УСУГ-ын холбогдох албан хаагчдаа хамтран 53 үйлдвэрийн ус хаях, зайлуулах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, холбогдох албан хаагчдад зөвлөмж өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. | |
| 1.12 | **Зорилт 1.12.** Усны нөөцийг бохирдлоос хамгаалах, хэмнэх, дахин ашиглах, бохирдуулагч нь | Төсөв шаардахгүй | Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоо | 2020 онд 18 удаа сургалтыг зохион байгуулсан.<br><br>Шинээр хийгдэнэ. | Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт, дүрэм, журмыг сурталчлан таниулах цахим сургалтыг 6 удаа | Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоо<br><br>Суурилуулсан тоолуурын тоо<br>Бодлогын зөвлөмж | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөх зарчмыг хэрэгжүүлэх | | Суурилуулсан тоолуурын тоо<br>Бодлогын зөвлөмж | | зохион байгуулсан байна.<br>Хаягдал усны тоолуурыг суурилуулж, туршилт үр дүнд үндэслэн боловсруулсан бодлогын зөвлөмж - 1 | | |
| 1.12.1 | **Арга хэмжээ 1.12.1.** Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх, дагалдан гарсан дүрэм, журам, бусад эрхзүйн актуудыг олон нийтэд сурталчлан танилцуулах, түгээн дэлгэрүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах | Төсөв шаардахгүй | Мэдээ, мэдээллийг бэлтгэх,<br><br>Зохион байгуулсан сургалт, оролцогчдын тоо | 2021 онд 18 удаа сургалтыг зохион байгуулсан. | Жилийн эцэст: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт, дүрэм, журмыг сурталчлан таниулах цахим сургалтыг 18 удаа зохион байгуулсан байна. | Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, дагалдан гарсан дүрэм, журам, аргачлал, стандартуудын талаар нийт 20 сургалт зохион байгуулснаас ,60 гаруй байгууллагын 838 хүнийг хамруулсан.<br>. | 100 хувь |
| 1.12.2 | **Арга хэмжээ 1.12.2.** Усны нөөцийг зохистой ашиглах, хэмнэх, бохирдуулагч нь төлөх зарчмыг хэрэгжүүлэх | Төсөл хөтөлбөр /АХБ/ | Суурилуулсан тоолуурын тоо<br><br>Бодлогын зөвлөмж | Шинээр хийгдэнэ. | Эхний хагас жилд: Орхон-Чулуут голын сав газарт сонгогдсон 6 аж ахуйн нэгжид хаягдал усанд бохир усны тоолуур суулгах туршилтын ажлыг “Усны засаглалыг шинэлэг арга замаар бэхжүүлэх нь” | Усны засаглалыг шинэлэг арга замаар хэрэгжүүлэх нь төсөл”-ийн хүрээнд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор Орхон-Чулуут голын сав газарт сонгогдсон 4 аж ахуйн нэгж байгууллагатай “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулж, 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Архангай, Өвөрхангай аймагт сонгогдсон 4 ААНБ-ын | 100 хувь |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
